

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ  
2024 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

## АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	1
1.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ .....	1
1.2. ХӨРВӨХ ЧАДВАР .....	2
1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД.....	2
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ .....	3
2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ .....	3
2.1.1. Хувьцааны арилжаа .....	3
2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа .....	5
2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа .....	5
2.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа .....	6
2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ .....	6
2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц .....	6
2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	7
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД.....	8
3.1. Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид .....	10
3.2. Мөнгөн хөрөнгийн номинал дансны тайлан .....	11
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА.....	11
4.1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа .....	11
4.2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа .....	12
ТАВДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ.....	13
5.1. Хууль, эрх зүйн орчны шинэчлэл.....	13
5.2. Эрх зүйн зохицуулалт.....	14
5.3.Хамтын ажиллагаа .....	15
5.4.Гадаад хамтын ажиллагаа .....	16
5.5.Гадаадын хөрөнгө оруулагчдыг татах чиглэлээр .....	17
5.6. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдлээ .....	17
5.7. Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай .....	18


## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хөгжлийн түвшнийг үнэлж, тогтоох хүрээнд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн голлох үзүүлэлтүүд болох дараах индикаторуудыг оруулсан байдаг: зах зээлийн үнэлгээ, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хөрвөх чадвар, хувьцааны индекс.

### 1.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2024 оны жилийн эцсийн байдлаар 13.02 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх улиралтай харьцуулахад 7.61 хувиар өссөн, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.78 хувиар өссөн бөгөөд уг үзүүлэлт нь 2023 оны үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ний 18.49 хувьтай тэнцэж байна.

График 1. ДНБ-д харьцуулсан хөрөнгийн зах зээлийн үнэлгээ



Тайлбар: 2024 оны ДНБ гараагүй тул 2023 оны ДНБ-тэй харьцуулж тооцоолов.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг бүрдүүлж байгаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 174 компаниас дараах 30 компанийн зах зээлийн үнэлгээ 12.18 их наяд төгрөгийн үнэлгээтэй байгаа нь хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээний 93.51 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 30 компани


№	Компанийн нэр	Эзлэх хувь	№	Компанийн нэр	Эзлэх хувь
1	“ХААН банк” ХК	17.44%	16	“Монголын хөрөнгийн бирж” ХК	0.95%
2	“Тавантолгой” ХК	13.76%	17	“Лэндмн ББСБ” ХК	0.87%
3	“Худалдаа хөгжлийн банк” ХК	9.78%	18	“Богд банк” ХК	0.80%
4	“АПУ” ХК	8.18%	19	“Гутал” ХК	0.64%
5	“Голомтбанк” ХК	7.71%	20	“Монгол шуудан” ХК	0.60%
6	“Хас банк” ХК	6.68%	21	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	0.59%
7	“Инвескор ББСБ” ХК	5.08%	22	“Түмэн шувуут” ХК	0.59%
8	“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК	4.22%	23	“Монложистикс холдинг” ХК	0.59%
9	“Төрийн банк” ХК	2.95%	24	“Эм Жи Эл Акуа” ХК	0.46%
10	“МИК холдинг” ХК	2.64%	25	“Газар шим үйлдвэр” ХК	0.46%
11	“Премиум нэксус” ХК	1.78%	26	“Тэнгэрдаатгал” ХК	0.42%
12	“Говь” ХК	1.55%	27	“Тандэм инвест ББСБ” ХК	0.38%
13	“Монгол даатгал” ХК	1.23%	28	“Улаанбаатар бүк” ХК	0.35%
14	“Сүү” ХК	1.16%	29	“Мандал даатгал” ХК	0.34%
15	“Улсын Их Дэлгүүр” ХК	0.97%	30	“Техник импорт” ХК	0.33%

Тайлбар: Зах зээлийн үнэлгээнд 100 хувь төрийн өмчит компанийн үнэлгээ ордоггүй болно.

## 1.2. ХӨРВӨХ ЧАДВАР

Тайлант хугацаанд хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар өмнөх улиралтай харьцуулахад 0.67 пунктээр, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.98 пунктээр тус тус өсөж, 2.48 хувьд хүрсэн байна. Манай улсын хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар бага байгаа нь хувьцааны хэт төвлөрөлтэй холбоотой юм. Тухайлбал 2024 оны жилийн эцсийн байдлаар ТОП-20 индексэд багтах ХК-уудын хувьцааны төвлөрлийг тооцож үзэхэд хэт төвлөрөлтэй буюу нийт хувьцааны 81.80 хувийг 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

График 2. Хөрвөх чадвар (хувиар)



## 1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД

“Монголын хөрөнгийн бирж” ХК-аас ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргадаг. ТОП-20 индексээр зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компанийн, MSE-A болон MSE-B индексээр үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хувьцааны үнийн индексийг тус тус харуулдаг байна.

Хүснэгт 2. Индексийн үзүүлэлт

Индекс	2023.IV	2024.III	2024.IV	Өөрчлөлт /2024.III-2024.IV/	Өөрчлөлт /2023.IV-2024.IV/
ТОП 20	41,437.42	47,864.47	51,296.39	7.17%	23.79%
MSE A	17,574.53	18,360.61	19,795.97	7.82%	12.64%
MSE B	11,327.14	15,410.49	15,197.38	-1.38%	34.17%

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

ТОП-20 индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 51,296.39 нэгж, доод үзүүлэлт 40,704.45 нэгж, дундаж үзүүлэлт 45,889.91 нэгж байна. Өмнөх улиралтай харьцуулахад 3,431.92 нэгжээр буюу 7.17 хувиар өсөж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9,858.97 нэгжээр буюу 23.79 хувиар өсөж **51,296.39** нэгж болсон байна.

MSE-A индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 19,842.43 нэгж, доод үзүүлэлт 16,294.41 нэгж, дундаж үзүүлэлт 17,932.79 нэгж байна. Өмнөх улиралтай харьцуулахад 1,435.36 нэгжээр буюу 7.82 хувиар өсөж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,221.44 нэгжээр буюу 12.64 хувиар өсөж, **19,795.97** нэгж болсон байна.

Харин MSE-B индексийн дээд үзүүлэлт 15,444.11 нэгж, доод үзүүлэлт 11,321.67 нэгж, дундаж үзүүлэлт 13,503.28 нэгж байна. Өмнөх улиралтай харьцуулахад 2,023.05 нэгжээр

буюу 15.11 хувиар өсөж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 213.11 нэгжээр буюу 1.38 хувиар буурч, **15,197.38** нэгж болсон байна.


## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

### 2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ

2024 оны жилийн эцсийн байдлаар нийт **1.58** их наяд төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.01 дахин өссөн үзүүлэлт бөгөөд өдрийн дундаж арилжаа **6.3** тэрбум төгрөг байна. Нийт арилжааны 1.49 их наяд төгрөгийн арилжаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар, 91.46 тэрбум төгрөгийн арилжаа хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар тус тус хийгдсэн байна.

Тайлант хугацаанд компанийн өрийн хэрэгслийн арилжаа түлхүү явагдсан бөгөөд нийт үнэт цаасны арилжааны 57.79 хувийг компанийн өрийн хэрэгсэл, 22.68 хувийг хувьцаа, 13.04 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 6.48 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа тус тус эзэлж байна.

График 3. Үнэт цаасны арилжааны хэмжээ (бүтээгдэхүүний төрөл, хувиар)




#### 2.1.1. Хувьцааны арилжаа

График 4. Хувьцааны арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд нийт 358.34 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 46.44 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Үүнээс хувьцааны анхдагч зах зээлд нийт 34.81 тэрбум төгрөгийн, хоёрдогч зах зээлд нийт 323.53 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан байна.



Хоёрдогч зах зээл дээрх хувьцааны арилжааг арилжаа эрхлэх байгууллага дээр бүртгэлтэй, арилжааны хэмжээгээрээ тэргүүлэгч 30 компанийн арилжааны мэдээллийг үнийн дүнгээр харуулбал:

*Хүснэгт 3. Арилжааны хэмжээ хамгийн өндөр 30 компанийн арилжааны үнийн дүн (тэрбум төгрөгөөр)*

№	Компанийн нэр	Үнийн дүн	№	Компанийн нэр	Үнийн дүн
1	“Говь” ХК	72.10	16	“Монложистик холдинг” ХК	4.82
2	“ХААН банк” ХК	39.11	17	“Ард кредит ББСБ” ХК	4.56
3	“Инвекор ББСБ” ХК	35.64	18	“Тэнгэрлиг медиа групп” ХК	3.41
4	“Улсын Их Дэлгүүр” ХК	20.28	19	“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК	3.07
5	“Инновэйшн инвестмент” ХК	14.67	20	“Газар шим үйлдвэр” ХК	3.03
6	“АПУ” ХК	12.45	21	“Лэндмн ББСБ” ХК	2.68
7	“Голомтбанк” ХК	11.92	22	“Э транс ложистикс” ХК	2.66
8	“Монголын хөрөнгийн бирж” ХК	10.61	23	“Улаанбаатархивс” ХК	2.48
9	“Премиум нэксус” ХК	9.84	24	“Төрийн банк” ХК	2.25
10	“Худалдаа хөгжлийн сан” ХК	7.91	25	“Түмэн шувуут” ХК	2.12
11	“Сэндли ББСБ” ХК	7.83	26	“Монгол шуудан” ХК	1.80
12	“Богд банк” ХК	7.47	27	“Мандал даатгал” ХК	1.72
13	“Тавантолгой” ХК	7.41	28	“Ард даатгал” ХК	1.35
14	“Хас банк” ХК	6.94	29	“Моносхүнс” ХК	1.02
15	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	6.72	30	“Эрдэнэтхүнс ХК	0.97
<b>НИЙТ</b>					<b>308.80</b>

*Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК*

Тайлант хугацаанд нийт 26 хувьцаат компанийн 285.11 сая ширхэг буюу 120.83 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий багцын арилжаа хийгдсэн нь нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 38.05 хувийг эзэлж байна.

*Хүснэгт 4. Багцын арилжаа хийгдсэн компаниуд*

№	Үнэт цаасны нэр	Арилжаалагдсан ширхэг (мянган ширхэг)	Үнийн дүн (тэрбум төгрөг)
1	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	526.32	1.49
2	“Ард кредит ББСБ” ХК	25,632.58	2.56
3	“АПУ” ХК	5,978.23	6.01
4	“Бидисек” ХК	200.00	0.25
5	“Баянгол зочид буудал” ХК	23.90	0.84
6	“Богд банк” ХК	19,198.88	1.62
7	“Премиум нэксус” ХК	35,110.62	6.53
8	“Газар шим үйлдвэр” ХК	40,000.00	2.61
9	“Голомтбанк” ХК	3,405.18	4.78
10	“Инвекор ББСБ” ХК	4,281.20	32.56
11	“Айтүүлс” ХК	7,656.92	0.50
12	“Говийн өндөр” ХК	62.67	0.01
13	“ХААН банк” ХК	5,640.41	5.85
14	“Эм Жи Эл Акуа” ХК	2,144.70	0.39
15	“Монложистик холдинг” ХК	18,557.24	3.88
16	“Монгол шуудан” ХК	1,838.83	1.29
17	“Оллоо” ХК	1,725.31	0.02


18	“Инновэйшн инвестмент” ХК	66,987.97	13.19
19	“Сэндли ББСБ” ХК	38,463.69	7.27
20	“Сүү” ХК	619.50	0.25
21	“Эрдэнэтхүнс” ХК	368.54	0.97
22	“Худалдаа хөгжлийн банк” ХК	95.56	3.07
23	“Тэнгэрлиг медиа групп” ХК	570.51	2.39
24	“Тавантолгой” ХК	13.51	0.47
25	“Улаанбаатархивс” ХК	61.75	2.46
26	“Улсын их дэлгүүр” ХК	6,242.42	19.54
<b>НИЙТ</b>		<b>285,106.42</b>	<b>120.83</b>

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

### 2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа

График 5. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд компанийн өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжаагаар 745.72 тэрбум төгрөгийн, хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 167.37 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.61 дахин өссөн үзүүлэлт юм.




### 2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсанаас хойш 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 34 компани хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо 6 компанийн хувийн хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэж, улмаар тус хувийн сангууд үүсгэн байгуулагдсан байна.

График 6. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа (тэрбум төгрөгөөр)



Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлд нийт 102.42 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж өмнөх оны мөн үеэс 68.40 хувиар өссөн үзүүлэлт юм.

График 7. Тайлант хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжааны задаргаа

Тайлант хугацаанд хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн нийт 102.42 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэнээс биржээр арилжаалагддаг хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангаар **10.96** тэрбум төгрөгийн арилжаа, хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар **91.46** тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь тус тус нийт арилжааны 10.7 болон 89.3 хувийг бүрдүүлж байна. Хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн нийт


хоёрдогч зах зээлийн арилжааны 34.76 хувийг буюу **31.79** тэрбумын арилжаа нь нэгж эрхээ эргүүлэн худалдан авах арилжаа байна.



### 2.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

График 8. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаагаар 120.00 тэрбум төгрөгийн арилжаа, хоёрдогч зах зээлд нийт 86.09 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, нийт 206.09 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 3.25 дахин буюу 224.55 хувиар өссөн үзүүлэлт юм.



## 2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ


Тайлант хугацаанд **204,770** шинэ данс, **81,475** холболтын данс шинээр нээгдэж өссөн дүнгээр нийт **2,598,064** данс, **671,937** холболтын данс “ҮЦТХТ” ХХК-д бүртгэлтэй байна.

### 2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц

График 9. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны үнийн дүнд эзлэх хувь

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нийт хоёрдогч зах зээлийн арилжаанд дотоодын иргэний хийсэн арилжаа 170.05 тэрбум төгрөг (31.61 хувь), дотоодын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 359.71 тэрбум төгрөг (66.87 хувь), гадаадын иргэний хийсэн арилжаа 3.83 тэрбум төгрөг (0.71 хувь), гадаадын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 4.35 тэрбум төгрөг (0.81 хувь)-

ийг тус тус эзэлж нийт 537.94 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.



Эх сурвалж: "МҮЦКТ" ХХК

Дээрх арилжаанд давтагдсан тоогоор нийт 128,492 хүн, 2,489 аж ахуйн нэгж оролцож, 331,433 удаагийн арилжаа хийсэн байна. (Дэлгэрэнгүйг доорх хүснэгтээс харна уу.)

Хүснэгт 5. Хөрөнгө оруулагчдын бүтэц (давтагдсан тоо, хувиар)

	Арилжаанд оролцогчийн тоо		Арилжаанд оролцсон тоо	
Гадаадын ААН	146	0.11%	836	0.25%
Гадаадын иргэн	914	0.70%	3,461	1.04%
Дотоодын ААН	2,343	1.79%	17,986	5.43%
Дотоодын иргэн	127,578	97.40%	309,150	93.28%
<b>Нийт</b>	<b>130,981</b>	<b>100%</b>	<b>331,433</b>	<b>100%</b>


Эх сурвалж: "МУЦКТ" ХХК

### 2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс буюу 2021 оны 09 дүгээр сараас 2024 оны жилийн эцэс хүртэлх хугацаанд биржийн бус зах зээлд 148 компанийн 4.18 их наяд төгрөг, 178.3 сая ам.долларын үнийн дүн бүхий 280 өрийн хэрэгсэл бүртгэгдэж, үүнээс 3.4 их наяд төгрөг, 117.5 сая ам.долларыг татан төвлөрүүлсэн.

Харин тайлант хугацаанд 95 компанийн нийт 1,781.9 тэрбум төгрөг, 91.8 сая ам.долларын үнийн дүн бүхий 131 өрийн хэрэгсэл бүртгэгдэж, 1,670.2 тэрбум төгрөг, 71.9 сая ам.долларыг татан төвлөрүүлсэн. Энэхүү татан төвлөрүүлсэн дүн нь өмнөх оны мөн үеэс 3.25, 4.23 дахин тус тус өссөн үзүүлэлт байна.


График 10. Тайлант хугацаанд ББЗЗ-д бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийн дүн болон бодит татан төвлөрүүлсэн дүн



Тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийн бүртгэгдсэн дүнг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар нь ангилбал эрчим хүч 38.4 хувь, банк 8.6 хувь, банк бус 38.0 хувь, худалдаа үйлчилгээ 4.9 хувь, барилга 4.5 хувь, уул уурхай 3.6 хувь, бусад салбар 2.0 хувийг бүрдүүлж байна.

Харин тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийн тоог дүнг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар нь ангилбал банк бус 51.9 хувь, борлуулалт 13.7 хувь, барилга 12.2 хувь, үйлдвэрлэл 4.6 хувь, уул уурхай 3.8 хувь, банк 1.5 хувь, бусад салбар 12.2 хувийг бүрдүүлж байна

График 11. Тайлант хугацаанд ББЗЗ-д бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийн дүн болон тоог үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар ангилсан тоон мэдээлэл (хувиар)



## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

Өнөөдрийн байдлаар үнэт цаасны зах зээл дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Инновацийн тухай хууль зэрэг хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр хууль болон бусад холбогдох дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлж байна.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй 307 зохицуулалттай этгээд байна.

Хүснэгт 6. Үнэт цаасны зах зээлд оролцогчид

№	Үйл ажиллагааны төрөл	Тоо
<b>Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч</b>		
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	3
2	Үнэт цаасны клирингийн байгууллага	2 <sup>1</sup>
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага	1
4	Үнэт цаасны төлбөрийн байгууллага	1 <sup>2</sup>
5	Хөрөнгө оруулалтын менежментийн компани	34
6	Хамтын хөрөнгө оруулалтын сан /хаалттай, нээлттэй/	6
7	Кастодиан банк	3

<sup>1</sup> Тус тоонд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болох “Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК болон “МҮЦКТ” ХХК орсон болно.

<sup>2</sup> “ҮЦТХТ” ХХК нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон төлбөрийн үйл ажиллагааг үзүүлдэг.

8	Үнэт цаасны компани	53
	Брокер	52
	Үүнээс:	
	Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэгч	17
	Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээний үйлчилгээ үзүүлэгч	21
	Дилер	34
	Андеррайтер	26 <sup>3</sup>
	Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч	21 <sup>4</sup>
9	Хөрөнгө итгэмжлэн удирдагч	8
10	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч	1
11	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөлтэй компани	64 <sup>5</sup>
12	ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	1
13	ХАА-н биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	9
14	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	1 <sup>6</sup>
15	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/	13 <sup>7</sup>
16	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага	3
<b>Бүртгэлтэй хөндлөнгийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд</b>		
17	ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэгч байгууллага	71 <sup>8</sup>
	Аудитын үйлчилгээ үзүүлэгч байгууллага	54
	Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч байгууллага	24
18	ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч байгууллага	44
<b>Нийт (Тусгай зөвшөөрөл болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын тоо)</b>		<b>307</b>

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 174 ХК байна. Мөн Хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 273 дугаар тогтоолоор “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ГҮТББ-ыг, 2015 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийг өөрийгөө зохицуулах байгууллагаар тус тус бүртгэсэн.

*Хүснэгт 7. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй ХК-ийн тоо болон зах зээлийн үнэлгээ*

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын нэр	Бүртгэлтэй ХК-ийн тоо	Зах зээлийн үнэлгээ 2024
1) “Монголын хөрөнгийн бирж” ХК <i>-100 хувь төрийн өмчит -Төрийн өмчийн оролцоотой -Бусад</i>	<b>172</b> 3 11 158	12,993,665,407,286.30 ₮ <i>(Тус биржийн зах зээлийн үнэлгээнд 100 хувь төрийн өмчит компанийн үнэлгээ ордоггүй болно.)</i>
2) “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК	<b>2</b>	29,036,248,362 ₮
3) “Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК	-	-

<sup>3</sup> Тус тоонд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 банк /“Голомт банк” ХК, “Тээвэр Хөгжлийн банк” ХХК/ орсон болно.

<sup>4</sup> Тус тоонд хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх 1 хөрөнгө оруулалтын менежментийн компани /“Блак свон” ХХК/

<sup>5</sup> Тус тоонд “МИК ОССК” ХХК-37, “ҮЦСК” ХХК-5, “Носк тав ТЗК” ХХК-5, нээлттэй хүрээнд ХБҮЦ гаргасан 16 ТЗК, хаалттай хүрээнд гаргасан 1 ТЗК тус тус орсон.

<sup>6</sup> Тус тоонд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болох “Монголын хөрөнгийн бирж” ХК орсон болно.

<sup>7</sup> Нэр бүхий 9 үнэт цаасны компани тус үйл ажиллагааг давхар эрхлэн гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг авсан.

<sup>8</sup> ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэх үйлчилгээг зэрэг үзүүлдэг 7 компани байна.

### 3.1. Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид

2024 оны жилийн эцсийн байдлаар Хороонд бүртгэлтэй 53 үнэт цаасны компани байгаагаас үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон бусад хавсран эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй 52 үнэт цаасны компани байна. Үүнээс тайлант хугацаанд тайлан ирүүлсэн 51 үнэт цаасны компанийн нийт хөрөнгө 470.6 тэрбум, нийт орлого 28.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх улирлаас 19.84, 55.42 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Тус компаниудыг нийт хөрөнгийн хэмжээ болон нийт орлогын хэмжээгээр нь ангилан үзвэл дараах бүтэцтэй байна.

*Хүснэгт 8. Үнэт цаасны компаниудын хөрөнгийн болон орлогын шатлалын бүтэц*

Нийт хөрөнгө	Үнэт цаасны компаниудын тоо	Нийт орлого	Үнэт цаасны компаниудын тоо
0 – 100,000,000	5	0– 100,000,000	36
100,000,001 -1,000,000,000	20	100,000,001 - 1,000,000,000	8
1,000,000,001 ба түүнээс дээш	26	1,000,000,001 ба түүнээс дээш	7

2024 оны жилийн эцсийн байдлаар Хороонд бүртгэлтэй 32 хөрөнгө оруулалтын менежментийн компани байна. Тус компаниудын хувьд 42 хувийн хөрөнгө оруулалтын сан, 6 хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр удирдан ажиллаж байна.

Хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын нийт хөрөнгө 153.3 тэрбум, нийт орлого 16.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх улирлаас 11.59, 16.29 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Тус компаниудыг нийт хөрөнгийн хэмжээ болон нийт орлогын хэмжээгээр нь ангилан үзвэл дараах бүтэцтэй байна.

*Хүснэгт 9. Хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын хөрөнгийн болон орлогын шатлалын бүтэц*

Нийт хөрөнгө	Хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын тоо	Нийт орлого	Хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын тоо
0 – 100,000,000	9	0 – 100,000,000	28
100,000,001 -1,000,000,000	14	100,000,001 - 1,000,000,000	3
1,000,000,001 ба түүнээс дээш	9	1,000,000,001 ба түүнээс дээш	1

2024 оны жилийн эцсийн байдлаар Хороонд бүртгэлтэй 6 хамтын хөрөнгө оруулалтын сан байгаагаас 3 нь хамтын нээлттэй, 2 нь хамтын хаалттай, 1 хамтын хаалттай биржээр арилжаалагдах сан хэлбэртэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнээс тайлант хугацаанд 5 хамтын хөрөнгө оруулалтын сан тайлангаа ирүүлсэн бөгөөд хөрөнгө оруулалтын сангуудын нийт хөрөнгө 66.24 тэрбум, нийт орлого 7.24 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх улирлаас 251.12, 0.29 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Тус компаниудыг нийт хөрөнгийн хэмжээ болон нийт орлогын хэмжээгээр нь ангилан үзвэл дараах бүтэцтэй байна.

Хүснэгт 10. Хамтын хөрөнгө оруулалтын сангуудын хөрөнгийн болон орлогын шатлалын бүтэц

Нийт хөрөнгө	Сангуудын тоо	Нийт орлого	Сангуудын тоо
0 – 100,000,000	1	0 – 100,000,000	2
100,000,001 -1,000,000,000	1	100,000,001 -1,000,000,000	2
1,000,000,001 ба түүнээс дээш	3	1,000,000,001 ба түүнээс дээш	1

### 3.2. Мөнгөн хөрөнгийн номинал дансны тайлан

2024 оны жилийн эцсийн улирлын байдлаар Хороонд бүртгэлтэй номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлэгч 21 компани байна. Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс мөнгөн хөрөнгийн номинал дансны тайланг цахимаар хүлээн авахтай холбоотойгоор холбогдох ажлыг хийж гүйцэтгэсэнээр энэ оны эхний улирлаас компаниуд тайлангаа цахимаар ирүүлэх боломжтой болсон бөгөөд тайлант хугацаанд нийт 20 компани тайлангаа ирүүлсэн байна.


Тайлант хугацаанд дээрх 20 компанид бүртгэлтэй нийт 1,341,448 харилцагч байгаагаас 54,586 харилцагч үйлчилгээ авч, 371.6 тэрбум төгрөгийн болон 26.5 сая ам.долларын гүйлгээ хийсэн байна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА

### 4.1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

График 12. ХААБ-ээр арилжаалагдсан түүхий эдийн арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд Хөдөө аж ахуйн бирж нь 178 удаагийн цахим арилжаа зохион байгуулан 935 хэлцлээр нийт 995.9 тэрбум төгрөгийн үнэ бүхий бараа, түүхий эдийн арилжаа хийсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 27.62 тэрбум төгрөгөөр буюу 2.85 хувиар өссөн үзүүлэлт юм.



ХААБ-ээр дараах төрлийн бүтээгдэхүүнүүд арилжаалагдсан байна. Үүнд:


Зураг 1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа



*Хүснэгт 11. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны дүн (бүтээгдэхүүний төрлөөр)*

Ямааны ноолуур	889,693,894,136	Нийт арилжааны дийлэнх хувийг буюу 89.34 хувийг ямааны ноолуур, 7.24 хувийг ямааны завод ноос, 1.39 хувийг хонины ноос, 1.26 хувийг тэмээний ноос, 0.76 хувийг тосны ургамал, 0.01 хүнсний улаанбуудай тус тус эзэлж байна.
Хонины ноос	13,812,160,000	
Ямааны завод ноос	72,062,235,000	
Хонины завод ноос	29,150,000	
Тэмээний ноос	12,597,320,000	
Тосны ургамал (рапс)	7,580,881,950	
Хүнсний улаанбуудай	115,000,000	
<b>Нийт</b>	<b>995,890,641,086</b>	

*График 14. Нийт арилжаалагдсан хөдөө аж ахуйн биржийн арилжааны бүтэц (үнийн дүнд эзлэх хувиар)*



2024 оны жилийн эцсийн байдлаар хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий нэр бүхий 9 хуулийн этгээд байна. Үүнээс 2024 онд 995.89 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэний 6.45 хувийг “Алтан шагай инпекс” ХХК, 19.04 хувийг “Роял кашимер” ХХК, 18.76 хувийг “Хаан Тэлмэн” ХХК, 37.11 хувийг “Ханбүргэд Хэнтий” ХХК, 18.64 хувийг “Цэц инвест” ХХК тус тус бүрдүүлж байна.


**4.2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа**

2024 онд нийт 312 удаагийн арилжаагаар 22.37 сая тонн нүүрсийг 8.28 их наяд төгрөгөөр, 250 удаагийн арилжаагаар 2.42 сая тонн төмрийн хүдэр, баяжмалыг 567.77 тэрбум төгрөгөөр, 7 удаагийн арилжаагаар 17,615 тонн хайлуур жоншийг 9.98 тэрбум төгрөгөөр, 2 удаагийн арилжаагаар 6,000 тонн зэсийн баяжмалыг 40.5 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалж, нийт **571** удаагийн арилжаагаар **24.82** сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг **8.89** их наяд төгрөгөөр арилжаалсан ба өдрийн дундаж арилжаа **35.58** тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт арилжаалагдсан бүтээгдэхүүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад биет хэмжээгээр 1.59 дахин, мөнгөн дүнгээр 1.18 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тухайлбал өмнөх оны мөн үед нийт 299 удаагийн арилжаагаар 15.61 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 7.54 их наяд төгрөгөөр арилжаалсан байна.

*График 15. Нийт арилжаалагдсан нүүрсний хэмжээ (төрөл, ангилал, хувиар)*


- 1/3 коксжих нүүрс
- Баяжуулсан дунд зэрэг үнслэгтэй, сул коксжих нүүрс
- Баяжуулсан дунд зэрэг үнстэй хагас хатуу коксжих нүүрс
- Баяжуулсан коксжих нүүрс
- Баяжуулсан сул коксжих нүүрс
- Дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс
- Дэгдэмхий бодис дундаас их, хийн нүүрс
- дэгдэмхий бодис их хийн нүүрс
- чийг багатай хүрэн нүүрс
- Эрчим хүчний нүүрс



Тайлант хугацаанд нийт 10 төрлийн 22.37 сая тонн нүүрс арилжаалагдсанаас 1/3 коксжих нүүрс 40.83 хувийг, баяжуулсан коксжих нүүрс 11.56 хувийг, баяжуулсан дунд зэрэг үнслэгтэй, сул коксжих нүүрс 0.03 хувийг, баяжуулсан дунд зэрэг үнстэй хагас хатуу коксжих нүүрс 9.07 хувийг, баяжуулсан сул коксжих нүүрс 0.63 хувийг, дэгдэмхий бодис дундаас их, хийн нүүрс 1.14 хувийг, дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс 20.57 хувийг, эрчим хүчний нүүрс 14.88 хувийг, чийг багатай хүрэн нүүрс 1.23 хувийг, дэгдэмхий бодис их, хийн нүүрс 0.06 хувийг тус тус эзэлж байна.

График 16. Нийт арилжаалагдсан төмрийн хэмжээ (төрөл, ангилал, хувиар)

Тайлант хугацаанд нийт 2.42 сая тонн төмрийн хүдэр, баяжмал арилжаалагдсанаас 34.09 хувийг Fe-52%-ийн агууламжтай төмрийн хүдэр, 52.71 хувь Fe-58%-ийн агууламжтай төмрийн баяжмал, 13.20 хувийг Fe-65%-ийн агууламжтай төмрийн баяжмал тус тус бүрдүүлж байна.



Манай улсын хувьд 2024 оны байдлаар нийт 83.75 сая тонн нүүрс болон 7.51 сая тонн төмрийн хүдэр, баяжмал, 1.37 сая тонн жоншны хүдэр, баяжмал, 1.69 сая тонн зэсийн хүдэр, баяжмалыг тус тус экспортолсон байна. Үүнээс нүүрсний экспортын 26.71 хувь, төмрийн хүдэр, баяжмалын 32.22 хувь, жоншны хүдэр, баяжмалын 1.28 хувь, зэсийн хүдэр, баяжмалын 0.35 хувийг тус тус уул уурхайнбүтээгдэхүүний биржээр арилжаалсан байна.

Хүснэгт 12. УУББ-ээр дамжсан уул уурхайн бүтээгдэхүүний экспортын дүнд эзлэх хувь

Экспортын хэмжээ бүтээгдэхүүний төрлөөр	Нийт экспорт /сая, тонн/	УУББ-ээр арилжаасан /сая, тонн/	Эзлэх хувь
Нүүрс	83.75	22.37	26.71%
Төмрийн хүдэр, баяжмал	7.51	2.42	32.22%
Жонжшны хүдэр, баяжмал	1.37	0.017615	1.28%
Зэсийн хүдэр, баяжмал	1.69	0.006	0.35%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

## ТАВДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2024 онд Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, ТОП-100 ААН-ийг хөрөнгийн зах зээлд оролцуулах, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг зохицуулах, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах чиглэлд голчлон анхаарч дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

### 5.1. Хууль, эрх зүйн орчны шинэчлэл

Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Үнэт

цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо хариуцан боловсруулахаар тусгасан. Энэ хүрээнд Сангийн сайдын 2021 оны 52 дугаар

тушаалаар шинэчлэн баталсан “Хөрөнгийн зах зээлийн холбогдох хууль эрх зүйн орчинд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий” ажлын хэсгээс боловсруулсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэх Хөрөнгө оруулалтын сангийн

тухай хууль, Компанийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг авсан. Улмаар Засгийн газраас дээрх хуулийн төслүүдийг 2023 оны Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганд өргөн мэдүүлж, хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал дүгнэлтийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 2 дугаар тогтоолоор байгуулсан.

Тус ажлын хэсгийн зүгээс хуулийн төслийг эцэслэн боловсруулснаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулсан. Уг хуралдаанаар ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал тус бүрийг хэлэлцэж, гишүүдийн олонхын саналаар дэмжиж төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Харин эцсийн найруулгыг 2024 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар УИХ-ын гишүүдийн олонх дэмжиж улмаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэлийг хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Ийнхүү УИХ-аас Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталсан.

Хууль батлагдсантай холбоотойгоор Хорооны зүгээс шинээр болон нэмэлт, өөрчлөлт оруулахаар зохицуулсан холбогдох дүрэм, журмын төслийг боловсруулан шат дараатай батлуулан ажиллаж байна.



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар дотоодын аж ахуйн нэгжээс нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагаа хялбар, шуурхай болж, зохицуулагч болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн уялдаа холбоо сайжран олон улсын жишигт нийцэх, санхүүгийн технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэх, үнэт цаас гаргагч, андеррайтерийн компаниудын үүрэг оролцоо өсөх, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, төвлөрсөн болон тухайлсан бүртгэлтэй холбоотой зохицуулалт боловсронгуй болох зэрэг эерэг нөлөө хөрөнгийн зах зээлд бий болох юм.

### 5.2. Эрх зүйн зохицуулалт

2013 онд Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан тушаалаар баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам”-ыг Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагын дагуу болон зохицуулалтын орчныг боловсронгуй болгон өөрчлөн Санхүүгийн зохицуулах

хорооны дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 94/А/62 тоот хамтарсан тушаалаар шинэчлэн баталлаа.


Түүнчлэн Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаас 2022 оны 06 дугаар сард баталсан бөгөөд тус хууль нь 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор тус хууль хэрэгжиж эхлэхээс өмнөх хугацаанд хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхэлж байсан зарим компаниуд бүтцийн өөрчлөлт хийж өөр хуулийн этгээдэд үйл ажиллагааг шилжүүлэх эсхүл шинэ хуулийн этгээд байгуулан хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгүүлэх шаардлага тулгарсан бөгөөд тэдгээрийн хувьд Хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын зарим нөхцөл, шаардлагыг хангах боломжгүй болсон. Үүний хүрээнд Хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д Хорооны 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 248 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орууллаа.

Үүний сацуу Улсын Их Хурлаас 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг тус тус баталсан бөгөөд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.14-т “Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан Засгийн газар, аймаг, нийслэлийн болон Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаасыг борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох, суутган тооцох, төсөвт төлөх, тайлагнах журмыг санхүү, төсвийн асуудал

эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга хамтран батална” гэж заасан. Үүний дагуу Сангийн яам болон тус Хорооны зүгээс дээрх журмыг хамтран боловсруулж, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/105/239 дугаар хамтарсан тушаалаар баталсан.

### 5.3.Хамтын ажиллагаа

Санхүүгийн зохицуулах хороо Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран ТОП-100 аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “ТОП-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог өсгөх арга хэмжээний хөтөлбөр”-ийг 2023 оны 05 дугаар сард баталсан.



Энэхүү хөтөлбөрийн хүрээнд ТОП-100 аж ахуйн нэгжүүдэд IPO хийх, компанийн бонд гаргахад тавигддаг нөхцөл, шаардлага, цаг хугацааг бууруулж, IPO хийхэд хөрөнгийн үнэлгээ хийлгэхийг шаардахгүй байх, мөн нээлттэй, хаалттай хүрээнд бонд гаргахад барьцаа, батлан даалт шаардахгүй байх гэх зэргээр үнэт цаас гаргах ажиллагааг хялбаршуулах зохицуулалтуудыг холбогдох журмуудад тус тус тусгаж, нэмэлт, өөрчлөлт оруулан Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-т заасны дагуу Хорооны цахим хуудсанд 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр байршуулж, олон нийтээс санал авч, эцэслэн батлуулахаар ажиллаж байна.

Түүнчлэн уг хөтөлбөрийн хүрээнд ТОП-100 аж ахуйн нэгжүүд хөрөнгийн зах зээлд хувьцаа, компанийн бонд гаргахад тавигдах нөхцөл, шаардлага, хугацаа, өртгийг бууруулж, хялбаршуулах зохицуулалтуудыг бүрдүүлэх, холбогдох журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах төслүүдийг хамтран боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан төлөвлөгөөний дагуу холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Тухайлбал Санхүүгийн зохицуулах хороо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим болон мэргэжлийн оролцогч байгууллагуудтай хамтран аж ахуйн нэгжүүдийн хөрөнгийн зах зээлд хувьцаа, бонд гаргахад тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх, нээлттэй компани болсноор үүсэх давуу тал ач холбогдол болон IPO хийх процесс дараалал, компанийн засаглалын талаар зөвлөгөө, мэдээлэл өгөхөөр “Хөрөнгийн зах зээлийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх нэг цэгийн үйлчилгээ”-г 2024 оны 04 дүгээр сарын 23-аас 05 дугаар 14-ний өдрийг хүртэлх мягмар гаригуудад зохион байгууллаа.

Мөн Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран компаниудын удирдлагуудад зориулсан нээлттэй компани болоход тулгарч буй асуудал болон ажлын хэсгийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар танилцуулах, санал солилцох “Нээлттэй компани болохын давуу тал, хөрөнгийн зах зээлд үзүүлэх үр нөлөө” уулзалт, хэлэлцүүлгийг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр амжилттай зохион байгуулсан.

Уг хөтөлбөрийн хүрээнд ТОП-100 аж ахуйн нэгжүүд нь IPO хийх замаар нээлттэй хувьцаат компани болох, компанийн бонд гаргаж санхүүжилт татах замаар хөрөнгийн зах зээлд оролцсоноор бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлж, ашиг, орлогоо өсгөх, компанийн нэр хүндээ өсгөх, урт

хугацааны хямд санхүүжилтийн эх үүсвэр татах, компанийнхаа засаглал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зэрэг чухал ач холбогдолтой юм.

#### **5.4. Гадаад хамтын ажиллагаа**

Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлийн бодлого зохицуулалтыг сайжруулах, хяналт, шалгалтын орчныг сайжруулах, хүний нөөцийг чадавхжуулах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд дараах хамтын ажиллагааны санамж бичгүүдийг байгууллаа:

Санхүүгийн зохицуулах хороо Бүгд Найрамдах Киргиз Улсын Үндэсний банктай хоёр улсын санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, тэр дундаа финтек компаниудыг бодлогоор дэмжих, хил дамнасан санхүүгийн үйл ажиллагааны мэдээлэл солилцох, газар дээрх санхүүгийн хяналт шалгалт хийхэд харилцан туслалцах, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлд хамтран ажиллахаар 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.



Санхүүгийн зохицуулах хороо Унгар Улсын Төв банктай хоёр улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг бодлогоор дэмжихийн зэрэгцээ бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг хөгжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах чиглэлд харилцан туслалцах, хил дамнасан санхүүгийн үйл ажиллагааны мэдээлэл солилцох, газар дээрх хяналт шалгалт хийхэд харилцан туслалцах мөн хүний нөөц,

байгууллагыг чадавхжуулах чиглэлд хамтран ажиллахаар 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.

### **5.5. Гадаадын хөрөнгө оруулагчдыг татах чиглэлээр**

Хорооны зүгээс гадаадын хөрөнгө оруулагчдыг татах хүрээнд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, нэн ялангуяа хөрөнгийн зах зээлийг гадаадын хөрөнгийн зах зээлтэй холбох, хөрөнгө оруулагч нарт сурталчлах, дотоодын аж ахуйн нэгжүүдийг олон улсын зах зээлээс хөрөнгө оруулалт татахад дэмжлэг үзүүлэх чиглэлд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.



Тухайлбал олон улсын зохицуулагч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа тэлэх, Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсад таниулан сурталчлах чиглэлээр цуврал арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

2023 онд “Mongolian capital markets day-2023” арга хэмжээг БНХАУ-ын Шанхай хотод, “Mongolia’s Capital Market Connectivity” арга хэмжээг БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгд, 2024 онд “Монголын хөрөнгө оруулалтын долоо хоног” арга хэмжээг Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк хотноо, “Mongolia’s Capital Market Connectivity” арга хэмжээг Бүгд найрамдах Сингапур Улс болон Бүгд Найрамдах Солонгос Улсад тус тус зохион байгуулаад байна.

Тус арга хэмжээнүүдээр дамжуулан гадаадын хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгч

болон бусад зах зээлийн оролцогч нарт Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал болон арга хэмжээ зохион байгуулж буй улс дахь хөрөнгийн бирж дээр үнэт цаас гаргах, давхар бүртгүүлэх боломжийн талаар мэдээлэл түгээх зорилготой юм.

### **5.6. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдлээ**

Засгийн газрын 2024 оны 73 дугаар тогтоолоор 2023 оны 223 дугаар тогтоолд нэмэлт оруулж, "Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангилал"-д зэс, молибдены баяжмал болон бүтээгдэхүүнийг тус тус нэмсэн.



Үүний хүрээнд “Монголын хөрөнгийн бирж” ХК-аас “Зэсийн баяжмалын арилжааны гэрээний стандартыг тогтоох, мөрдүүлэх журам”-ыг баталж, Хорооны 2024 оны 134 дүгээр тогтоолоор журам мөрдүүлэх зөвшөөрлийг авсан бөгөөд зэсийн баяжмал амжилттай арилжаалагдаж эхэлсэн.

Зэсийн баяжмал уул уурхайн бүтээгдэхүүний биржээр дамжуулан арилжаалагдаж эхэлсэн нь арилжаа олон нийтэд нээлттэй, шударга, ил тод зохион байгуулагдаж, бүтээгдэхүүн үнийн өсөлттэй арилжаалагдах, экспортыг нэгдсэн бодлогоор хангах зэрэг олон давуу талыг бий болгож байгаа юм.

## 5.7. Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн ээлжит хуралдаанаар “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” Хорооны 2020 оны 28 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж, компаниудын ногдол ашиг тараах хугацааг нарийвчлан тогтоосон. Тодруулбал, ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн компаниуд санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор буюу дөрөвдүгээр сарын 30-ны өдрөөс өмнө ногдол ашгаа хуваарилж дуусган, тайлангаа Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлж байх үүргийг нийт хувьцаат компаниуд хүлээх юм.



Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Компанийн тухай хуулиар компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэхийг шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа дөрвөн сарын дотор хуралдуулах зохицуулалттай. Гэтэл зарим хувьцаат компаниудын хувьд ногдол ашиг хуваарилах шийдвэрээ гаргасан хэдий ч тараах хугацаагаа хувьцаа эзэмшигчдэд тодорхой зарлаагүй, эсхүл ногдол ашгаа тараахгүй удааж байгаа нь хувьцаа эзэмшигчдэд тодорхойгүй байдлыг бий болгохын зэрэгцээ зах зээлд итгэх итгэл болон идэвхийг бууруулах эрсдэлтэй тул уг асуудлыг шийдвэрлэх практик шаардлага үүссэн. Иймээс дээрх асуудлыг нарийвчлан зохицуулах ногдол ашиг тараах хугацаа болон тайлагналын талаар уг тогтоолд тодорхой зааж өөрчлөлт оруулсан. Ингэснээр компаниуд нийт хувьцаа эзэмшигчдийн хүртэх ногдол ашгийг тогтоосон хугацаанд дансанд нь байршуулж, тэдгээрийн эрх ашгийг хамгаалахад ихээхэн ач холбогдолтой юм.

ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР

---o-0-o---